

Монголын Маргааш



буюу 20... он

Мэдээллийн технологийн хөгжил
Монгол Улсын Ирээдүйд хэрхэн
нөлөөлөх вэ?

*Улсын Тэргүүний 24 дүгээр сургуулийн
мэдээлэл зүйн багш: П.Зохихсүрэн
e.mail: zoogoohon@gmail.com
Утас: 99000730*

**Та ямар төрлийн
үйлдлийн систем
ашигладаг вэ?**

**Таны хэрэглэдэг
үйлдлийн систем,
програм хангамж бүгд
албан ёсны зөвшөөрөл
лицензтэй юу?**

**Тэгвэл бидний хойч үеийн
суралцаж буй ЕБС-ийн
сургалтанд ашиглаж буй
компьютеруудын үйлдлийн
систем, програм хангамж
бүгд албан ёсны **зөвшөөрөл
лиценз**тэй юу?**

**ЕБС-ийн мэдээлэл зүйн
хичээлийн сургалт, мэдээлэл
зүйн багш нарт тулгамдаж
буй ямар асуудал байна вэ?**

**Сургалтын болон сургуулийн
удирдлагуудын компьютер
вирустэх, систем гэмтэх
хүндрэл бэрхшээлүүд
мэдээлэл зүйн багш нарын
ажлын ачааллыг нэмэгдүүлж
үндсэн сургалтандаа
анхаарах цагийг хомсолж
байдаг.**

**Энэ асуудлыг шийдвэрлэх
боломж, гарц бидэнд бий
юу?**

**Энэ асуудлыг шийдвэрлэх
боломж, гарц бидэнд бий
юу?**

Манай улс хөгжихийн хирээр дэлхийн хөгжилтэй орнуудын жишгээр оюуны бүтээлийг албан ёсны зөвшөөрөлтэй хэрэглэх шаардлага зүй ёсоор тулгарна. Тиймээс өнөөдрөөс эхлэн үр хүүхдүүдээ энэ сэтгэлгээнд сургах хэрэгтэй болов уу?

Биднийг өчнөөн зүйлийг сургахад тусалсан ВИНДОВС үйлдлийн системийг бид албан ёсны зөвшөөрөлтэйгээр худалдаж авч хэрэглэж сурах, ийм соёл бидний өмнө хэзээ нэгэн цагт ирнэ гэж бодож байна.

Нийслэлийн Боловсролын Газрын
мэдээлэл зүйн сургалт хариуцсан арга
зүйч Б.Цогбадрахын илтгэлээс иш
татан багахан тоо баримтыг харуулъя.

Програм хангамж худалдаалагчдын үнийн судалгаа



Бүтээгдэхүүн		Prise	Economy	Busines
Windows-7	Home	\$ 199,99	\$ 199,99	
	Ultimate	\$ 219,99		
	Professional	\$ 299,99		\$ 299,99
MS-Office-2007	Home & Student	\$ 149,95	\$ 149,95	
	Professional	\$ 499,95		
	Ultimate	\$ 679,95		\$ 679,95
Kaspersky	Anti-Virus 2010	\$ 39,95	\$ 39,95	\$ 39,95
Adobe	Photoshop CS4	\$ 699,00		\$ 699,00
	Indesign CS4	\$ 699,00		\$ 699,00
	Dreamweaver CS4	\$ 399,00	\$ 399,00	\$ 399,00
Nero 9	Box version	\$ 99,99		\$ 99,99
PowerDVD 9	Ultra (download)	\$ 79,95		\$ 79,95
			\$ 788,89	\$ 2 996,83

Нийслэлийн болосвролын ТӨСВИЙН НЭГДСЭН ДҮН



- ЕБС-иудад зориулж **62'142.6** мянган төгрөг
 - Цэцэрлэгүүдэд 34'231.4 мянган төгрөг
- Нийт дүнгээр **96'374** мянган төгрөг
- НЗД-ийн мөрийн хөтөлбөрт нэг хүүхдэд ноогдох компьютерын тоог 28 байсныг 19 болгоно
 - Гэвч програм хангамжид огт төсвөлдөггүй.
- Хэрвээ програм хангамжид энэ төсвийн мөнгөнөөс өгвөл хэдэн хувь нь зарцуулагдах вэ?

Програм хангамж худалдан авбал төсөв дийлэх үү?



	Economy	Busines
нэг компьютерын програм хангамжийн үнэ	\$788,89	\$2 996,83
Доллорын ханш, 1323,3₮, 2010-09-13	1 043 938₮	3 965 705₮
Нийслэлийн ЕБС-ийн компьютер 4149ш	4 331 299 330₮	16 453 710 622₮
Үүнээс төрийн ЕБС-н компьютер 2868ш	2 994 014 577₮	11 373 642 339₮
БЗД-ийн төрийн ЕБС-ийн 855 компьютерд	892 567 107₮	3 390 677 894₮
Нийслэлийн ЕБС-ийн нийт төсөв	62 142 600 000₮	62 142 600 001₮
Үүний хэдэн хувь нь програм хангаж болох вэ	7,0%	26,5%

НЭС-ийн шинэчлэлээр хийгдэж буй ажил:

- 2010 оны 1 сард мэдээлэл зүйн багш нарын семинар дээр 5 хоногийн сургалтаар UBUNTU-г хотын багш нарт заасан.
- Нийслэлийн ЕБС-ийн 24, 47, 93 дугаар сургуулиуд 2008-2010 оны хичээлийн жилүүдэд сургалтандаа нэвтрүүлэн ашиглаж байгаа.
- БЗД-ийн “Цахим сургалт” төслийн хүрээнд тус дүүргийн 19 сургуулийн “Багш хөгжлийн танхим”-ын компьютеруудад Edubuntu үйлдлийн системийг суулгасан.

Дэвшүүлж буй гарц, шийдэл:

Нийслэлийн мэдээлэл зүйн багш нарт болон багш мэргэжлээр их дээд сургууль төгсөгчдөд зориулан Нээлттэй эхийн системээр сургалт, семинар зохион байгуулах, ЕБС-ийн компьютерийн лабораториудын компьютеруудын үйлдлийн системийг Нээлттэй эхийн систем болох Ubuntu үйлдлийн системээр солих, шинэчлэн суулгах, ингэснээр компьютерийн лабораторид сурагчид мэдээллийн технологийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлээд зогсохгүй бүх төрлийн сургалтын програмуудыг ашиглан бусад хичээлүүдийг сонирхолтой байдлаар судлах боломж бүрдэх юм.

Мөн мэдээллийн технологи чиглэлээр мэдээлэл зүйн багш бэлтгэдэг Их дээд сургуулийн сургалтын системд Нээлттэй эхийн системийг нэвтрүүлбэл нэлээд үр ашигтай гэж үзэж байна.

UBUNTU-г сургалтад ашиглахад гарч буй шинэчлэлүүд юу вэ?

UBUNTU үйлдлийн системийг боловсролын салбартаа албан ёсоор **ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ** ашиглах боломжтой.

Боловсролд зориулсан програм хангамжийн сан ихтэй учир зөвхөн мэдээлэл зүйн хичээлд төдийгүй бусад шинжлэх ухааны хичээлүүдэд өргөн ашиглах боломж бүхий хэрэглэхэд хялбар програмуудтай.

Сурагчид бие даан болон хамтарч өөрөө өөрсдийгөө хөгжүүлэх, шинэ зүйлийг суралцах үйлийн баримжааг эзэмших боломж өндөртэй.

Сургалтын компьютеруудыг байнга форматлах, засвар үйлчилгээ хийх шаардлагагүй.

Хамгийн чухал нь сурагчид бие биендээ туслах, хамтарч суралцах арга барилд суралцах, **“ХАМТДАА ХӨГЖИЦГӨӨЕ”** уриан доор хүнлэг, энэрэнгүй сэтгэлгээтэй болж, ЗӨВ хүн болж төлөвшдөг.

ВИНДОВС-ийн эрсдлээс болж **“ЭХ ОРОНЧ”** сэтгэлгээ нь давамгайлдаг

UBUNTU-г сургалтад ашиглахад илэрч буй хүндрэл бэрхшээлүүд юу вэ?

Сургалтын орчин бүрдээгүй, өмнө нь ВИНДОВС-ыг хэрэглэж заншсан учир гэнэт **ҮБҮНТҮ**-рүү шилжилт хийхэд хүндрэлтэй.

Энэ чиглэлээр сургалт явуулахад мэдээлэл зүйн багш нар бүрэн бэлтгэгдэж чадаагүй байгаа

Сургууль, төрийн үйлчилгээний байгууллагууд бүгд ВИНДОВС-ыг ашиглаж байгаа

Өмнө нь Виндовс үйлдлийн системийг хэрэглээд заншчихсан учир ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгараад мэдэхгүй, чадахгүй зүйл гарвал Виндовс системээ ашигладаг.

ДҮГНЭЛТ

Бид бүхний туршиж үзэхээс эмээдэг шинэ бүхнийг оюутан сурагчид маань аль хэдийн хэрэглээндээ нэвтрүүлчихжээ. Тиймээс UBUNTU буюу нээлттэй эхийн програм хангамжийг сургалтандаа ашиглах, хэрэглэх чадвар эзэмших шаардлага мэдээллийн технологийн мэргэжлийн **БАГШ** бүрийн өмнө тулгарч байна. Иймээс МТ-ийн мэргэжлийн багш нараа мэргэшүүлэх ажлыг яаралтай гүйцэтгэх шаардлагатай байна.